



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 18

Өмнөдэлгэр сум

2025 онд ойн сангаас уламжлалт бүтээгдэхүүн
нөхөрлөл болон багийн ахуйн хэрэгцээнд бэлтгэх
модны дээд хязгаар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг, 32.3.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын ойн сангаас 2025 онд мод бэлтгэх уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нөхөрлөл болон багийн ахуйн хэрэгцээний модны дээд хязгаарыг модны төрлөөр хавсралтаар баталсугай.

2.Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор нас гүйцсэн ургаа нойтон мод ойгоос бэлтгэсэн иргэн огтолсон нэг модны оронд арав буюу түүнээс дээш тооны тарьц суулгацыг ойд тарьж ургуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавьж, тайланг хагас, бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Р.Энхтөр), Хэнтий шинэс сум дундын ойн ангийн дарга (Г.Мөнх-оргил) нарт даалгасугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн
ээлжит Гуравдугаар хуралдааны 18 дугаар
тогтоолын хавсралт

2025 онд Өмнөдэлгэр сумын ойн сангаас уламжлалт бүтээгдэхүүн
үйлдвэрлэх, ойн нөхөрлөлүүд болон багийн ахуйн хэрэгцээний мод бэлтгэх
дээд хязгаар /огтлолын төрөл шоометр/

№	Нөхөрлөл болон багийн нэр	Модны төрөл	Цэвэрлэгээний ажил м3				Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор м3		
			Хэрэглээ	Түлээ	Бүгд	га	Хэрэглээ	Түлээ	Бүгд
1	Лаглуу нөхөрлөл	шинэс		40	40	2			
2	Баруун жаргалант нөхөрлөл	шинэс	10	40	50	2			
3	Баян өлзийт нөхөрлөл	шинэс	20	60	80	3			
4	Өгөөмөр нөхөрлөл	шинэс	30	70	100	4			
5	Мангирт нөхөрлөл	шинэс	50	100	150	6			
6	Чандмань нөхөрлөл	шинэс	20	50	70	3			
7	Нөөлөгт	шинэс	20	40	60	2			
8	Наран баг	шинэс	50	400	450				
9	Баян зүрх баг	шинэс	150	500	650		30	10	40
		нарс					20	10	30
		хуш					20	10	30
10	Хэнтий баг	шинэс	200	800	1000		30	10	40
11	Талын булаг баг	шинэс		100	100				
12	Чандган баг	шинэс		100	100				
13	Төвийн баг	шинэс	50	500	550				
14	Гурван баян тосгон	шинэс	100	700	800				
Нийт			700	3500	4200	22	100	40	140